



ТАВ. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

1. Газрын нэр: Техник, технологийн ашиглалтын газар

1.1. Зорилго: Компанийн техник технологи, сүлжээний ашиглалт үйлчилгээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж сайжруулахад оршино.

1.2. Зохион байгуулалтын бүтэц



1.4. Үйл ажиллагааны чиг үүрэг:

Зорилгыг биелүүлэх ажлын хүрээнд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Харилцаа холбоо, мэдээллийн технологи, кабелийн телевиз, ОТТ, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангах;
- Техник технологийн ашиглалт үйлчилгээг оновчтой зохион байгуулах;
- Техник, технологийн өргөтгөл шинэчлэлд судалгаа хийж, сүлжээний төлөвлөлт гаргах;
- Хэрэглэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлэх.

2. Албаны нэр: Техникийн ашиглалт үйлчилгээний алба

2.1. Зорилго: Техникийн ашиглалт үйлчилгээний найдвартай байдлыг хангах, гэмтэл саатлыг шуурхай засварлаж, хэрэглэгчдэд чанартай үйлчилгээг үзүүлэхэд оршино.

2.2. Зохион байгуулалтын бүтэц:



2.3. Үйл ажиллагааны чиг үүрэг: Дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: Үүнд:

- Улаанбаатар хот, орон нутгийн msan болон soft switch станц, дамжуулах байгууламж, National кабелийн ТВ, ОТТ, зай тэжээл хөргөлт агааржуулалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд 24 цагийн хяналт тавьж ажиллах, гэмтэл саатлыг хяналтын хугацаанд багтаан засварлах;
- Тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, ачааллын судалгааг гаргаж, дүгнэлт өгөх, урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээний ажлыг батлагдсан графикийн хүрээнд чанартай хийх, өргөтгөл суурилуулалт шилжүүлгийн ажлыг технологийн дагуу гүйцэтгэх;
- Ашиглалт үйлчилгээний гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллах;
- Техникийн ашиглалт үйлчилгээний горим, стандарт, дүрэм журмыг боловсруулах, мөрдөж ажиллах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг инженер техникийн ажилтнууд мөрдөж хэвшүүлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх.

3. Албаны нэр: Интернэтийн ашиглалт үйлчилгээний алба

3.1. Зорилго: Компанийн хөгжлийн чиг хандлага болсон мэдээллийн технологийн сүлжээ, системийн найдвартай ажиллагааг хангаж, гэмтэл саатлыг шуурхай засварлаж, хэрэглэгчдэд чанартай үйлчилгээг үзүүлэхэд оршино.

3.2. Зохион байгуулалтын бүтэц:



3.3. Үйл ажиллагааны чиг үүрэг: Дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: Үүнд:

- Компанийн хэмжээнд ашиглагдаж байгаа интернэтийн үйлчилгээ, өгөгдлийн сан, программ хангамжуудын хэвийн ажиллагааг хангах, тэдгээрийн төхөөрөмжүүдийн ашиглалт, үйлчилгээг хариуцах;
- Интернэтийн үйлчилгээний болон программ хангамжийн өргөтгөл, шинэчлэлийн оновчтой шийдэл гаргах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх;
- Интернэтийн болон дотоод VPN сүлжээ, гэх мэт бусад системүүдийн аюулгүй, найдвартай байдал, техник технологийн хэвийн ажиллагааг хангах, өргөтгөл шинэчлэлийг зөв оновчтой зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- Компанийн дотоод хэрэгцээнд (цаг бүртгэл, санхүү, КаТВ, серверүүд г.м.) ашиглагдаж байгаа программ, системүүдийн харилцан холболт, сервер төхөөрөмжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Удирдлага болон бусад нэгжүүдийг бодит мэдээллээр хангах;
- А зөвшөөрөл бүхий байгууллагуудтай интернэтийн харилцан холболт хийх, тухайн холболтын хэвийн найдвартай ажиллагаанд хяналт тавьж үйлчилгээний чанарт онцгой анхаарах;
- УБ болон орон нутгийн интернэт үйлчилгээг өдөр тутам хянаж асуудал гарсан тохиолдолд цаг алдахгүй шийдвэр гарган, үйлчилгээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах;
- ТАҮА-тай хамтран КаТВ, ОТТ, xPON, MSAN төхөөрөмжүүдээр интернэт үйлчилгээг хэрхэн оновчтой харилцан холболт хийх, дамжуулах чиглэлээр нягт уялдаатай ажиллах;
- Бүсийн болон аймаг, дүүргийн инженер техникийн ажилтнуудад интернэт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр технологийн заавар зөвлөмж өгөх, сургалт, мэдээллээр хангах.